

СОЁЛ

**МАНЖ УГСААТНЫ ГАРАЛ
ҮҮСЭЛ, ТҮҮХ, СОЁЛЫН
ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ**

Ж. ӨЛЗИЙ

I. Манж Зөрчидийн гарал үүсэл, овог

Манж (Зөрчид) угсаатны гарал үүсэл, түүний овгийг ихэнх эрдэмтдийн бичсэнээр Тунгус үндэстний салаа мөчир буюу Зөрч (Жүрж) овогтон гэдэг байна.

Эдгээр Зөрчид буюу жүрж овогтны групп нь шинэ цусан төрлийн угсаатан болж олширон нэмэгдэж хамгийн эцэст 600 гаруй Манж хала (овогтон) болон бүрэлдэж ирсэн түүхтэй. Манж нар нь гол төлөв оршин сууж байсан газар нутаг, ан амьтан, өвс ургамлаар овоглогдож иржээ. Жишээ нь: Уссури (мөрөн), Ниохэ (чоно), Сақда (зэрлэг мэгж), Нимаха (загас), Торо (тоор) овогтон гэх мэт болно.

Ер нь Манж угсаатны овог Хятадын Суй улсаас өмнөх судар бичигт маш ховор тохиолдох боловч Тан улсаас хойш нилээд бичигдэж иржээ. Хятадын Лю Цинхуа гэгч судлаач 1960 оны дунд үеэс нааш зүүн хойд 3 муж, Хэбэй муж, Бээжин хот зэрэг 20 гаруй хот, сян-аар явж Манж угсаатны түүх, соёл зан заншлын талаар судалгаа хийж Манж угсаатны овгийн онцлог, гарал үүсэл, хувиралт зэргийн байдлыг нэлээд тодорхой бичсэн байна. Тэрээр «Шинэ Тан улсын судар-Бохайн шасдир»— зэрэг түүхэн сурвалж бичгийн үндсэн дээр манж нарын овогийн гарал үүслийг 6 хэсэгт багтаажээ.¹ Үүнд:

1. Газар усны нэрээр овоглосон овог

Газар усны нэрээр овоглох нь оршин сууж байсан газрын нэрээр овоглохыг хэлж байна. Жишээ нь «Сақда» хэмээх нэртэй газарт **үе улиран сууж байсан манж нар** «Сақда» гэдэг овогтой болж, Уссури мөрний хавьд сууж байсан манж нар өөртөө Уссури гэж овог өгчээ.

2. Аймгийн нэрээр овоглох

Манж нар овог аймгийнхаа нэрээр овоглох тал байдаг. Жишээ нь: Хар мөрний дэд захирагч Долун-у, түүний өвөг дээдэс Нимаачаа аймагт харъяалагдаж байсан учраас Нимаачаа хэмээх овогтой болжээ. Энэ мэтээр аймгуудын нэрээр Вэньтэхэ овог, Хэшээлий овог, Тугтай овог, Нараа овог зэрэг олон овгуудыг дурдаж болно.

3. Хуучин овогуудаар овоглох

Хуучин овогуудаар овоглох нь гол төлөв Алтан (Жин), Юан улсын үеийн зөрчид нарын овоглож байсан овогуудаар овоглохыг хэлж байна. Жишээ нь: «Хуанчао тунчжи-Шицзу люе-И синь вэйши» хэмээх бичигт (Хаан ордны ойлго бичиг) нэрэлсэн 35 овгийн дотроос Алтан улсын үеийн 27, Ляо улсын үеийн 1, Юан улсын үеийн 7 овог тус тус зөрчидийн хуучин овогоор овогложээ.

¹ «Миньцзу яньцзю» 1983. № 1, 64-66-р талд

4. Хааны хайрласан овог

Энэ нь өөрийн үндсэн уг овгоор биш, харин эзэн хааны хайрласан овгоор овоглохыг хэлнэ. Жишээ нь, «Хуанчао тунчи-Цы-синь» хэмээх бичигт тэмдэглэснээр Манж Чин улсын эхэн үед байсан Гуаржаа овогтой дотоод их түшмэлийг эзэн хааны хайрласан Убай овгоор овоглох болжээ.

5. Халж өөрчилсөн овог

Халж өөрчилсөн овог гэдэг нь өрх тусгаарлах болон өөр газар нутагт шилжин нүүх зэрэг шалтгаанаас болж шинэ овгоор овоглохыг хэлнэ.

Жишээ нь, Иргэнгеор овогтон үржиж олшроод баруун зүүн хоёр хэсэгт хуваагдсаны баруун хэсгийг нь Мэн-Элү, зүүн хэсгийг нь Баяр гэж овоглох болсон тухай дээр дурдсан хааны ордны ойлго бичгийн 10-р ботид дурджээ.

6. Өвөг дээдсийн нэрээр овоглох

Өвөг дээдсийн нэрээр овоглох нь өвөг дээдсийн нэрэнд орсон аль нэг үсгээр түүний үе залгамжлагчид өөрийн овог болгон авсныг хэлнэ. Жишээ нь, Чин улсын сүүлийн үед Шэньян Дунлин хэмээх газарт амьдарч байсан Шитар овогийн Вэнь Чжун-э гэгч хүний үр ач нар Вэнь гэсэн үсгээр овоглох болжээ. Түүнчлэн Манжийн ноёрхолын нэгэнт түгэн дэлгэрсэн үед ч манж угсаатны эрдэмтэд, албаны түшмэд зэрэг дээд давхаргын төлөөлөгчид хүртэл төрөлх овог нэрээ хэрэглэхээ больж Жуй Чжунтан (Жуй түшмэл-ред), Вэнь Чжунтан (Вэнь түшмэл ред) гэх мэт овог цолын Жуй, Вэнь зэрэг зохиомол хятад овгийг Линь, Фу гэх мэт хятад нэрсийн хамт хэрэглэж Ихэнара, Фэймо хэмээх манж овгоо бүр орхижээ. Ийм байдлаас Манжийн үндсэн овог нь цөөрч хятад үндэстэнд аяндаа уусан орохын шинж тэмдэг болжээ.

С. М. Широкогоров манж зөрчид овгийн бүрэлдэхүүнийг нэлээд няхуур судалж «Манж угсаатны нийгмийн байгуулал» гэдэг ном бичсэн нь 1924 онд Токиод япон хэл дээр хэвлэгджээ. Тэрээр манж угсаатныг 66 овгоос бүрдсэн гэж дээрх зохиолдоо тэмдэглээд түүнээс 40 гаруй овгийн нэрийг жагсаажээ.²

Эдгээр овгуудын дотор зарим нийтлэг, онцлогоороо судалгааны ач холбогдолтой, угсаа зүйчдийн сонирхлыг татахуйц цөөн овогийг жишээлж болох юм. Үүнд:

— Гуаржа, хятадаар Гуан, манжаар Хоржа энэ овог хуучин манж овогтон бөгөөд хожим Хятад (никан) болж уусчээ.

— Геро, хятадаар Цзяо, манжаар Киоро. Энэхүү хуучин манж овогтноос урьд хан, ван язгууртан тарсан гэдэг. Геро гэдэг бол өлсгөлөн гэсэн үг юм. Үүнийг манж нарын тайлбарласнаар бол эрт дээр үед тэд нар туйлын ядуу байсан тул хоол гуйж явсан гэдэг. Герог манжийн аман яриагаар зэрлэг ямаа гэдэг юм. Үүнийг нь хэлэхэд манж нар дургүй байдаг. Гирин мужид Геро нэртэй нэгэн гацаа ч байжээ.

— Мон-гу, мэн-гүн. Монгол манж овогтон. Энэ овогтоны бүрэлдэхүүнд багтдаг Байрин, Дараа, Охо, Үр-ий зэрэг овгуудыг Монгол овогтон гэж хэлдэг. Тэд хятад овог нэр авдаггүй бөгөөд уул овог нэрээрээ овоглодог байна. Тэд Шаньдун мужийн монголчуудтай залгаа сууж бай-

² С. М. Широкогоров «Манж угсаатны нийгмийн байгуулал» Токио 1924 27 48 дахь талд

гаад Монголд уусч монгол овог нэртэй болж монголчуудын ёс, зан заншлыг нь авсан бололтой.

— Око монгу, хятадаар О, манжаар Око. Око монгу нь жинхэнэ монгол үг гэдэг. Монгол овогтой манж нар. (Око буюу Ооку нь манжаар анжисны хошуу гэсэн утгатай).

— Үү-рий монгоо. Хятадаар у, манжаар Үүрий монгоо. Монгол манж овогтон.

— Татар, хятадаар дада, манжаар татар. Хуучин манж овогтон гэх мэт болно. Манж овгуудыг тэнгэрийн тэтгэсэн хааны үе (1744)-ийн түүх судар, 1920 онд хэвлэгдсэн 8 хошуу манж овогтны нэвтэрхий бичиг зэрэгт тэмдэглэжээ.

II. Мин улсын үеийн зөрчид угсаатны аймаг, түүний газар нутаг

Зөрчидүүд гурван мянган жилийн өмнө Чансайшань (мөнх цагаан уул), Хар мөрний уудам өргөн газар нутагт нутаглаж байжээ.

XV—XVI зууны үед Зөрчид аймгийн нийгмийн байгуулалын хэлбэр нь гэрийн боолын дүрэмд нэгэнт шилжин ороод бичиг соёлын үүдийг нээсэн байна. Энэ үед овгийн байгуулал нь аажмаар сарнин нурж байв.

Мин улсын үед Зөрчид аймгийг Хай-ши, Жан-жү, Е-рин гэж 3 аймагт хувааж байв. XIII зуун Юан улсын үед одоогийн Чанбайшаний тал Муданцзян мөрний урсгал дагуу Жан-жүүгийн зөрчид нар нутаглаж байжээ. Бүр Тан улсын үед ч Уссури мөрний салбар урсгал Мүлү голын нутаг Маулин гэдэг Жан-жүгийн зөрчидийн харъяа газар байжээ. Одоогийн Сунгар мөрний Тунжаншаний хойт тал Хар мөрний өмнөд, хойд хоёр хөвөөгөөр Ерингийн зөрчид нар нутаглаж байв.

Тай-зу Нурхачи Манжийн олон аймгийг уриалан нэгтгэж Хар мөрөн, Сунгар мөрөн, Уссури мөрөн зэрэг газраар дэвсгэр нутаг болгож 1615 онд хожуу Алтан улсыг байгуулжээ.

Хар мөрний дээд урсгалын Дагуур угсаатан эртний монгол хэлээр, Хар мөрний дунд урсгалын зөрчид нар зөрчид хэлээр, Хар мөрний доод урсгалын Орчоон нар Манж, Тунгус хэлээр ярьдаг ажээ.

Хятад улс дахь Манж Зөрчид угсаатан өнөө үед Хар мөрөн муж, Гирин муж, Ляонин муж, Хэбэй муж, Бээжин, Өвөр Монгол, Или зэрэг газар нутгаар тархай бутархай сууцгааж байна.³

Манж угсаатны Хүр-ха, Ужаараа, Сахарча, Солон аймгууд 1950 бүгд 23700 хүн амтай⁴ байсан гэх ба Ляо улсын «Бүрэн ойлго бичгийн» II ботид бичсэнээр 391496 хүнтэй⁵ байжээ.

Орчин үед тус угсаатны хүн ам нь 2430 000 гэж тэмдэглэгдсэн байна.⁶

Манж угсаатныг пэ-манжу (хуучин манж) ичээ-манжу (шинэ манж) мон-гу манжу (монгол манж) гэсэн гурван салбар хэсэгт манжийн хаан Нурхачи хувааж цэргийн зохион байгуулалтанд оруулж морьт, буут, явган цэргийн 8 хороо (хошуу) болгожээ. Тэрээр монгол (барга), хятад, эвинк, Хар мөрөн, Хөлөн буйрын солон, дагуур нарыг ч цэргийн зохион байгуулалтанд оруулжээ. Нурхачи манжид цэргийн ийм зохион байгуу-

³ Мо Дунинь. Манж үндэстний түүхийн өгүүллүүдийн эмхэтгэл, Бээжин. 1958. 5-р тал. (Хятад хэл дээр)

⁴ Ёо Иш-да, Кин-Ичи, Орос, Чин улсын харилцаа, Токио, 1974. 23-р талд

⁵ Мо Дунинь. Дурдсан зохиол. 97-р талд

⁶ Шинэ Хятад толь бичиг. Бээжин, 1962. 38-р талд

лалт хийгээд өмнө тийш Хятадыг дайрсан гэж Манжийн өндөр настнууд ярьдаг байжээ.

Манж нар цөөн тооны Монгол газрыг дагуулан авч цэргийн зохион байгуулалтанд оруулсан учир тэднийг шинэ манж буюу Монгол манж угсаатан гэдэг болжээ. Шинэ Манжид Эвинк, Дагуур, орчсон Солон ууд ч багтаж байв.

III. Мин улсын үеийн Зөрчид, Монголын холбогдол

Мин улсын эхний жилүүдэд зүүн Монгол угсаатан болон Зөрчид, Манж угсаатнууд Хятадын зүүн хойд хэсэгт нутаглаж байжээ. Ингэж 200 гаруй жилийг өнгөрөөсөн түүхтэй ажээ. Харин хоёр угсаатны харилцаа тийм ч найрсаг байж чадсангүй.

1621 онд хожуу Алтан улсын цэрэг Монголын Жарууд зэрэг олон аймгийн Бээл нарыг алж хөрөнгийг дээрэмдэн⁷ олзолж авчирсан Монголын охид хөвгүүдийг боол шивэгчин болгож Шаньдун, Хэбэй зэрэг мужийн эзэд ба ноёдод худалдан өгдөг байв. Мөн арилжаа наймааны талаар монголчуудыг янз бүрийн аргаар доромжлон хязгаарладаг учир Монголын ард түмэн тэднийг ясандаа ортол хорсож байлаа.

Нурхачи Цахарын Лигдэн хааны харьяат Хочин аймгийн язгууртнуудтай залт аргаар худ ураг болсон учир Харчин Мянганы бээл нар 1622 онд 3000 өрх айлыг дагуулж хожуу Алтан улсад дагаар оров. Мөн Бэгз, Гонгор нарын хошуу 1624 онд хожуу Алтан улсын харьяат аймаг болов. Монголын бусад хошуудын дээд давхаргаатан ингэж дараа дараагаараа дагаар орсон байна.

1628 оны 8-р сард Лигдэн хааны удирдсан Өмнөд Цахар, Бадрахын удирдсан Хойд халх аймгийн цэрэг нийлж Харчин аймагт довтолж 11-р сард Харчины Эбажиншив хотыг бүслэв. Нурхачи түүнийг сонсоод Гонгороор толгойлуулсан Харчины 7 Бээлийн цэргийг нэмэн мордуулсныг Лигдэн хаан сонсоод цэргээ хурдан ухраав.

Монголын тархай бутархай аймгууд хүчээ нэгтгэж чадсангүй тул Нурхайчид ялагдав. Тэгээд Нурхачи Зүүн хойт орныг нэгтгэсний дараа Монгол нь баруун талд нь оршиж Зөрчид нь зүүн талд нь оршин нутаглах болжээ.

Мин улсын эхний жилүүдэд нэг хэсэг монголчууд Цзяньчжоугийн Зөрчид аймгуудад багтаж Зөрчидийн айл гацаанд суусан байна.⁸

Зөрчидийн амьдрал муутай хүмүүс монгол айлд очиж хөлсний ажил хийдэг байжээ. Нурхачи өөрөө ч монгол айлд ажил хийдэг байснаар барахгүй Буянтай хэмээх монгол аймгийн ахлагчийн охин дүүтэй гэрлэсэн ажээ.

Харин аймгийн ахлагч нь цөм Зөрчид хүмүүс байсан байна. Зөрчид хүмүүс монгол хэл сурч байсан гэх ба Нурхачи ч мөн монгол бичиг мэддэг байжээ.⁹

IV. Манж, Зөрчидийн соёл, зан үйлээс

1. Манж нарын хэл, соёл. Манж хэл бол манж зөрчид угсаатны хэл юм. Монгол хэл бол Түрэг лүгээ нэг салбарын Алтай хэлний төрөлд багтана.

⁷ «Миньцзу яньцзю» сэтгүүл. 1983. No 4 (хятад хэл дээр) 46-р талд

⁸ Солонгосын хаадын үнэн тэмдэглэл. 27-р боть. 466-р тал. (хятад, япон дээр)

⁹ Чин улсын бүрэн түүх, дэд дэвтэр. 101-р тал (хятад хэл дээр)

Сунгар мөрний суугаал ардын хэл бол Уссури мөрөн, Хар мөрөн нутгийнхны адил манж бичгийн үгэнд маш ойрхон байдаг юм. Эдгээр ардын хэлний онцлог нь зүүн Монголын нэгэн бүлэг Баргад угсаатны хэлтэй төсөөтэй бөгөөд Хойт зүгийн Тунгус хэлний авиа их ордог.

XVII зууны сүүлийн хагаст Чин улс хөгжин бадрахын хамт манж хэл нь Хятадын төв орон дахь хятад үгтэй хольцолдож манж хэлний дотор хятад үг олон тоотой ордог болсон бөгөөд, хэл зүйн хувиралт ч гарсан байна.

Одоо Манж угсаатны дотор төрөлх манж хэлээр ярьдаг хүн маш ховор болохын хамт хятад үг хэл нь манж угсаатны төрөлхийн хэл болон хувирсан байна.

Харин Хятадын баруун хойд орны Или дахь Манж, Шивээгийн ар дууд үндэсний манж хэл бичгээ нэлээд хэмжээгээр хадгалж байгаа тул Хятад дахь манж нар ихээр чухалчлан үздэг бололтой.

Алтан улс Тай-зу Агуда хаан 1119 онд хятад бичгийг дуурайлган кидан үсгийн дүрмийг хэрэглэж улсын бичиг хэмээн зөрчид бичгийг зохиолгов. Энэ бичиг Мин улсын эхэн үед хэрэглэгдэж байсан боловч Мин улсын дунд үеэс Зөрчид (манж) угсаатан монгол үсгийг хэрэглэж монгол бичгээр бичиг хэргээ хөтөлж байжээ.¹⁰

Манж нар боомтонд орохоос өмнө хуучин манж бичиг бинт, тусалгүй байжээ. Дараа нь Чин улсын Тай-зун хаанаас 1632 онд манж багш Эрдэнэ, Даахай нарт зарлиг буулгаж монгол үсгээс тусган авч 12 толгойн 1500 гаруй манж үсэгт бинт, тусал нэмж манж бичиг, зохиосон¹¹ байна.

Манж нар боомтонд орсны дараа манж угсаатанд манж бичгийг заан сургах зарлиг гаргаж, улсын бичиг болгон зарлаж улсын дотооддоо хааны зарлиг, Засгийн газрын зарлал, заавар, бичиг хэрэг, албан материал зэргийг цөм манж бичгээр гол болгон явуулж хятад монгол бичгийг нөхүүр болгон хэрэглэх хэлбэрийг авсан бөгөөд цэргийн явдлын чухал баримт бичиг, материал, гэрээ хэлэлцээрийн бичгийг ч манж хятад бичгээр явуулж байжээ.

Мөн түүх, хэл зүйн ухаанд ч манж бичгийг хэрэглэж байв. Чин улсын үед манж-хятад хэлний толь, манж, монгол, хятад, төвд, хотон зэрэг 5 хэлний толь зэрэг ном хэвлэл олонтой хэвлэгдэж манж бичгийн судалгааны материал ариаж ирсэн байна. Тусгайлан Или, Синьцзян орчмын манж гаралтай шивээ нар болон, манж угсаатны нэгэн салбарын сууж байгаа газар орны хэдэн арван мянган ард түмэнд манж хэл, бичиг чухал шаардлагатай болж бага сургууль дөрөв, дунд сургууль нэгийг тус тус байгуулжээ.¹²

2. Манж Зөрчидийн бөөгийн мөргөл. Манж Зөрчидийн бөөгийн мөргөл нь балар эртний хуучин чулуун зэвсгийн дунд үеэс эх үүсгэлтэй ажээ. Тухайн үед хүмүүсийн амьдрал, ухамсар маш бүдүүлэг байсан учир байгалийн гэнэтийн үзэгдлээс айн сүрдэж амь нас бүх амьдралаа тэнгэр газарт даатган залбирал үйлдэх болсон цаг үеэс бөөгийн мөргөл үүсэн гарсан байна. Мөн түүний дотор манж зөрчид угсаатны өвөг дээдэс ч багталцаж тэр үеэс бөөгийн мөргөлийг шүтэн биширч эхлээд манж нарын зарим нь 1960-аад он хүртэл шүтсээр байгаад хамгийн сүүлд

¹⁰ Ван Тунлин, Хятад үндэсний түүх. Бээжин. 1928. (хятад хэл дээр) 489 талд

¹¹ У Лу-гийн тэмдэглэл. 2-р боть, дээд 1-р талд. Мөн «Миньцзу Яньцзю» сэтгүүлийн No 4. Бээжин. 1983. 43-р талд

¹² Азийн түүхийн хэрэг үйлсийн толь. (8) Токио 1975 387-р талд

1966-аас 1967 онуудад Хятадын «Соёлын хувьсгал» гэгчээр бөөгийн мөргөл устгагдсан бололтой.

Манж бөөгийн өмсгөл нь: сахиусан малгай, буга, хандгайн арьсаар хийсэн хувцас, том жижиг толь, хонхоор чимсэн хормойвчтой өмсгөл хувцас, банзал, шаахай зэрэг байхаас гадна янз бүрийн тахилын багаж, тал хэнгэрэг, хутга, таяг, олон өнгийн даавуу, хадаг уясан шон мод зэрэг зүйл байдаг байна. Бөө бөөлөх үедээ байшингийн баруун талд 3 мод босгож түүгээр дамжуулан сахиус онгодоо дуудан оруулдаг байна.

Түүнийг сахиусны мод гэж нэрлэдэг ажээ. Гол дундах мод нь том байдаг бөгөөд түүний дээр нь могой, яст мэлхий, дөрвөн хөлт Аймий гэдэг сахиусны дүрсийг зурсан байна. Тэр модны үзүүрт сахиусан тагтаа шувуу байдаг. Энэ нь бөөгийн дуудлагаар Аймий сахиусан орж ирэх үед зам зааж өгдөг байна. Аймий сахиусан дүрс нь жижиг хүүхэд хэлбэртэй бөгөөд, тэрхүү сахиусны гэгээн туяагаар бөөгийн бие бүх юм үздэг гэж мунхруулдаг юм. Тэр модны нэрийг манжаар Само буюу Сало мод¹³ гэдэг байна.

Манж бөө нь өөрийн овгийн хүмүүсийн төлөө жилд 1 удаа Чанд (онгон сахиусыг дуудан бөөлдөг юм. Онгон сахиусаа тахих үед их бөө өмсгөл хувцсаа өмсөж багаж хэрэгсэл хутга, таягаа буюу тал хэнгэргээ барьж өндөр сандал дээр сууна. Туслагч бөө нь хажуу талд нь тал хэнгэргээ барьж зогсоно. Бөөгийн онгон оруулагч нь мөн хажуу талд нь бөөгийн дуудлага хийж (тэнгэр газар, овоо, өндөр уул, их гол мөрөнг) дуудаж онгод ормогц бөө ухаан мэдээ алдаж гол нуруугаараа татаж хүмүүсээр түшиж тулуулан байж өвчтөнийг хутгаар мэсдэх буюу таягаараа цохиж зоход зэрэг элдэвийн арга заслыг хийж гардаг байна. Энэ үед цугларсан хүмүүс бөөд сүсэглэн өргөл барьц өргөж сөгдөж мөргөнө. Ингээд бөө ухаан ороход өмсгөл хувцасыг нь тайлж бөөгийн онгон тахилга дуусна. Дараа нь цугларсан олноороо цай хоол идэцгээж архи, дарс ууцгаан бөө мөргөлийн тухай буюу мухар сүсэгийн элдэв яриа хууч хөөрөлдөж хурим найрын байдалтай болж тарцгаана .

3. Манж угсаатан Хятадад ууссан нь. Чин улсын Эебээр засагч хааны тэргүүн онд (1644) Манжийн эрх баригчдаас Хятадыг манжчлахад чиглэгдсэн зарим арга хэмжээ авч эхэлжээ. Түүний дотор хятад эмэгтэйчүүдийн хөлөө боох заншлыг хориглох, хятад иргэдийг тав гээг тавиулах, манж маягийн малгай, хувцас өмсүүлэх, манж, хятад хоорондоо ураг барилдах гэр бүл болохыг зөвшөөрөх зэрэг өөрчлөлт явуулж байжээ.

Төрийн хэргийг манж бичгээр хөтлөхийг чухалчилж манж, монгол 8 хошуунд сургууль байгуулж бичиг, судрын түшмэдүүдийг бэлтгэхийн зэрэгцээ манжийн 8 тугийн цэргийн зохион байгуулалтыг хийж жанжин, ду-тун Фу, (дэд) ду-тун гэх мэт цол, тушаал буй болгож хууль дүрмийг чангалж, дарангуйлан захирах бодлого баримталж байжээ. Гэвч эдгээр арга хэмжээний аль нь ч нэмэр болсонгүй. Харин эцсийн бүлэгт манж нар өөрсдөө хятадчилагдаж соёл, зан үйл төдийгүй, хэл яриа хүртэл хятад болж хувирчээ.

Манж нар хятадчилагдах үйл явц юуны өмнө том хотууд, төв суурин газруудаас эхэлсэн байна. Ялангуяа нийслэл Бээжингийн манж угсаатан нар эртнээс нааш хятад үндэстнийг дууриаж, зан заншлыг нь авч эхэлсэн бөгөөд бусад хольцолдон суух хошуу нутгуудад цөөнх нь болж хувирсан манж нар хятад зан заншлыг өдөр хоног тусам мөрдөх

¹³ Мо Дун-инь, Манж үндэстний түүхийн өгүүллүүдийн эмхтгэл. Бээжин. 1958. 175-р тал (хятад хэл дээр)

болж хятад хэл, бичиг сурч, идэж уух, босох суух хүртэл цөм хятад болон уусчээ.

Хятадчилагдах үйл явц гүнзгийрхийн хэрээр манж хэл бичиг ая мартагдаж, зан заншлаа орхиж харин манж эмэгтэйчүүд хятадтай адил хөлөө боож хятад маягийн хувцас өмсдөг болжээ. Сүүлийн үед манж нутагт хүртэл Хятадын засаг захиргааны уламжлалт нэгж болох чжоу, сянь байгуулагдах болжээ. Улмаар Манжийн Энх амгалан хааны үед буюу 1686 оноос хойш манж хошуудад хятад иргэд шилжин суурьшиж, атар хагалан газар тариалан эрхэлсэн сянь-ууд байгуулагджээ.

Манжийн бадаргуулт төр хааны үед (1887) Манжийн бүх газрыг хагалан дуусч он жил өнгөрсөөр манж нарын суугаа нутаг зүүн гурван мужийн газар эдэлбэрийн эрх мэдэл хятадуудын гарт шилжсэнээр үл барам засаг захиргаа, хүн ард бүхэн бүрнээ хятад үндэстэнд уусчээ. Гагцхүү дээр үеэс Манжийн хил хязгаар, хот, сууринг хамгаалах алба өчүүхэн хэсэг манж угсаатны тасархай энд тэнд үлдсэн бололтой.